

Усан замын тээврийн хэрэгслээр хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул, хохирол учруулж болзошгүй ачаа тээвэрлэх журмын танилцуулга

2022.09.19

Манай Улсад үндэсний усан замын тээвэр 1950-иад оноос хөгжиж, ОХУ-аас импортолж байсан бараа, шатах тослох материал бусад ачааг 1 чирэгч хөлөг онгоц, 3 чиргүүл /нэг нь шингэн ачааны/ онгоцоор Хөвсгөл нуураар Ханх, Хатгал боомтын хооронд, Сэлэнгийн усан замын газар гол төлөв үр тариа, модыг Т-63 илчит онгоц болон чиргүүлээр тээвэрлэж 1990 он гэхэд нийт 80.0 гаруй мянган тонн ачаа, 49.1 сая тн/км-ийн ажил гүйцэтгэж байв.

Улс орон зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэн 1990-ээд оноос хойш, ОХУ-аас импортлох барааны ачаа эргэлт үгүй болсон, мөн байгаль орчны асуудлаас болж усан замын тээвэр зогсонги байдалд орсон.

Энэ үед тус улсын томоохон гол, мөрөн, нууруудад цөөхөн усан замын тээврийн хэрэгсэл тоологдож байсан бол өнөөдөр зөвхөн Хөвсгөл нуурт иргэд, хуулийн этгээдийн 80 гаруй усан замын тээврийн хэрэгсэл байгаа ба цаашид нийт гол, мөрөн, нуурт улам бүр нэмэгдэх хандлагатай болж байна.

Эдгээр иргэд, хуулийн этгээд нь усан замын тээврийн хэрэгслээр аялагч, жуулчдад үйлчилгээ үзүүлэх болон амрагч, зорчигчдыг тээвэрлэхдээ тээврийн хэрэгслийнхээ тавцан дээр шатахууны нөөцөө хуванцар болон төмөр канистр саванд авч явдаг.

Энэхүү нөхцөл байдал нь хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул, хохирол учруулж болзошгүй байгаа. Мөн зах зээл өргөжин тэлэхийн хэрээр алс ирээдүйд усан замын тээврийн хэрэгслээр хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул, хохирол учруулах ачаа, тээш тээвэрлэж болзошгүй учир хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул, хохирол учруулж болзошгүй ачаа тээвэрлэх журмыг шинэчлэн боловсруулж батлуулах шаардлагатай байна.

Журам батлагдсанаар усан замын тээврийн хэрэгсэл эзэмшигч, жолоодогчид аюултай ачаа тээвэрлэх талаар зохих мэдлэг, чадвартай болж, зорчигч, аялагчдын аюулгүй байдал хангагдаж, болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх юм.

Усан замын тээврийн хэрэгслээр хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд аюул, хохирол учруулж болзошгүй ачаа тээвэрлэх журмын төсөлд хийсэн нөлөөллийн шинжилгээ

1. Журам батлуулах үндэслэл, шаардлага

Монгол Улсын Их Хурлын 2017 оны хаврын чуулганаар шинэчлэн баталсан Усан замын тээврийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т “усан замын тээврийн хэрэгслээр зорчигч, ачаа тээвэрлэх дүрэм болон хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул, хохирол учруулж болзошгүй ачаа тээвэрлэх журмыг усан замын тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж заасны дагуу уг журмыг шинэчлэн боловсруулж, төслийг усан замын тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаалаар батлуулна.

Манай Улсын усан замын тээвэр 1950-иад оноос 1980-аад оны сүүл хүртэл нилээд эрчимтэй хөгжиж байсан үед ОХУ-аас шатахуун, шатах тослох материалыг импортлож 300 тоннын багтаамжтай шатахуун тээвэрлэгч чиргүүл онгоцоор Хөвсгөл нуураар Ханх, Хатгал боомтын хооронд тээвэрлэж баруун аймгуудыг хангаж байлаа.

Усан замын тээвэр зогсонги байсан 1990-2009 онуудад тус улсын томоохон гол, мөрөн, нууруудад цөөхөн усан замын тээврийн хэрэгсэл тоологдож байсан бол өнөөдөр усан замын тээврийн хэрэгслийн улсын бүртгэлд 163, үүнээс зөвхөн Хөвсгөл нуурт иргэд, хуулийн этгээдийн 80 гаруй усан замын тээврийн хэрэгсэл тоологдож байгаа ба цаашид нийт гол, мөрөн, нуурт улам бүр нэмэгдэх хандлагатай болж байна.

Эдгээр иргэд, хуулийн этгээд нь усан замын тээврийн хэрэгслээр аялагч, жуулчдад үйлчилгээ үзүүлэх болон амрагч, зорчигчдыг тээвэрлэхдээ тээврийн хэрэгслийнхээ тавцан дээр шатахууны нөөцөө хуванцар болон төмөр канистр саванд авч явдаг.

Энэхүү нөхцөл байдал нь хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул, хохирол учруулж болзошгүй байгаа. Мөн зах зээл өргөжин тэлэхийн хэрээр алс ирээдүйд усан замын тээврийн хэрэгслээр хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул, хохирол учруулах ачаа, тээш тээвэрлэж болзошгүй учир хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул, хохирол учруулж болзошгүй ачаа тээвэрлэх журмыг шинэчлэн боловсруулж батлуулах шаардлагатай байна.

Ингэснээр усан замын тээврийн хэрэгсэл эзэмшигч, жолоодогчид аюултай ачаа тээвэрлэх талаар зохих мэдлэг, чадвартай болж, зорчигч, аялагчдын аюулгүй байдал хангагдаж, болзошгүй эрсдлээс хамгаалах, урьдчилан сэргийлнэ.

2. Журмын төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Журмын төсөл нь нийтлэг үндэслэл, аюултай ачааны тээвэрлэлтэд тавигдах шаардлагууд, тээвэрлэгчийн бүрэн эрх, аюултай ачааг ачиж буулгах болон шилжүүлэн ачих зогсоолд тавих шаардлага, тусгай зөвшөөрөл болон зөвшөөрөл олгох, хяналт тавих байгууллагын бүрэн эрх гэсэн хэсгүүдээс бүрдэнэ.

Журмаар хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул, хохирол учруулж болзошгүй ачаа, тээшийг усан замын тээврийн хэрэгслээр тээвэрлэх үед баримтлах аюулгүйн шаардлага, тээвэрлэлтэд оролцож буй хүн бүрт тавигдах шаардлага,

аюултай ачаа ачих, буулгах үедэх аюулгүйн ажиллагаа, зогсоолын байгууламжийн аюулгүй байдалд тавигдах шаардлага ачих буулгах тоног төхөөрөмж хангамж, бүрэн бүтэн байдал, тэдгээрийг аюулгүй ашиглах харилцааг зохицуулна.

Энэхүү журам нь усан замын тээврийн хэрэгсэл аялах боломжтой Монгол Улсын гол, мөрөн, нуураар хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул, хохирол учруулж болзошгүй ачаа, тээш тээвэрлэх хүн, хуулийн этгээдэд үйлчилнэ.

Журмыг зөрчсөн хүн, хуулийн этгээд нь Усан замын тээврийн тухай болон Зөрчлийн тухай хуульд заасан хэм хэмжээгээр хариуцлага хүлээнэ.

3. Журмын төсөл батлагдсаны дараа эрх, хууль ёсны ашиг сонирхол нь аливаа байдлаар хөндөгдөж болохуйц бүлгийг тодорхойлох

Журмын төсөл батлагдсаны дараа усан замын тээврийн хэрэгслээр ажил, үйлчилгээ эрхэлж буй хүн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь ямар нэг байдлаар хөндөгдөхгүй. Усан замын тээврийн хэрэгслээр үйлчлүүлэгч иргэд, аялагчдын болон аюултай ачаа тээврийн аюулгүй байдал хангагдаж, эрх ашиг нь хамгаалагдана.

4. Хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, өрсөлдөөнийг хязгаарласан, эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд саад хориг учруулсан, аливаа хүнд суртал, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт агуулж байгаа эсэх

Хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, өрсөлдөөнийг хязгаарласан, эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд саад хориг учруулсан, аливаа хүнд суртал, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт агуулаагүй болно.

5. Тухайн асуудлыг зохицуулж байгаа урьд нь батлагдсан шийдвэр байгаа эсэх, журмыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, санхүү, эдийн засгийн тооцоо.

Журмын төсөлд тусгагдсан харилцааг өмнө нь Зам, Тээвэр, Аялал Жуулчлалын сайдын 2006 оны 45 дугаар тушаалаар баталж зохицуулж байсан ч Захиргааны ерөнхий хууль, шинэчлэгдэн батлагдсан Усан замын тээврийн тухай хуульд заасан тавигдаж буй шаардлагын дагуу журмыг шинэчлэн боловсруулсан бөгөөд түүнийг хэрэгжүүлэхэд хүний нөөц, санхүү, эдийн засгийн зардал гарахгүй болно.

Журам батлагдсанаар усан замын тээврийн хэрэгслийн ахмад, жолоодогчид аюултай ачаа тээвэрлэхдээ ямар үйлдэл, үйл ажиллагаа хэрэгжүүлэх, тээвэрлүүлэгч, тээвэрлэгчийн харилцан хүлээх эрх, үүрэг, хариуцлагын талаар бүрэн дүүрэн мэдлэгтэй болж, улмаар хүний амь нас, эд хөрөнгө хохирох эрсдлээс урьдчилан сэргийлж, усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн аюулгүй байдал хангагдана.

Зам, тээврийн хөгжлийн сайдын
20... оны ... сарын ... -ны өдрийн
... дугаар тушаалын хавсралт

**УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛЭЭР ХҮНИЙ
АМЬ НАС, ЭРҮҮЛ МЭНД, ХҮРЭЭЛЭН БАЙГАА
ОРЧИНД АЮУЛ, ХОХИРОЛ УЧРУУЛЖ БОЛЗОШГҮЙ
АЧАА ТЭЭВЭРЛЭХ ЖУРАМ**

1. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү журмын зорилго нь хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул, хохирол учруулж болзошгүй ачааг /цаашид “аюултай ачаа” гэх/ усан замын тээврийн хэрэгслээр аюулгүй тээвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2 Аюултай ачаа гэдэгт Аюултай ачаа. Ангилал. Техникийн ерөнхий шаардлага MNS 4978:2000 стандартын 5.2-т болон 7.1-7.2-т заасныг болон Монгол Улсын Шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 54/A/136/A/215 дугаар хамтарсан тушаалын хавсралтаар баталсан “Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам”-ын 4 ба 6 дугаар Хүснэгтэд тодорхойлсныг ойлгоно.

1.3 Эрх бүхий байгууллагаас аюултай ачаа импортлох, ашиглах, тээвэрлэх тусгай зөвшөөрөл, эсхүл зөвшөөрөл авсан хүн, хуулийн этгээд /цаашид “тээвэрлүүлэгч” гэх/ -ийн ачааг холбогдох зөвшөөрлийг нь үндэслэн усан замын тусгай зориулалтын ачаа тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.

1.4 Энэхүү журмын хэрэгжилтэд Усан замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түүний харъяа мэргэжлийн байгууллага, Улсын мэргэжлийн хяналтын газар болон эдгээр байгууллагаас томилогдсон усан замын тээврийн улсын байцаагчид хяналт тавьж ажиллана.

2. Аюултай ачааны тээвэрлэлтэд тавигдах шаардлага

2.1 Усан замын тээврийн хэрэгслээр аюултай ачааг тээвэрлэхдээ “Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль”, Монгол Улсын Шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 54/A/136/A/215 дугаар хамтарсан тушаалын хавсралтаар баталсан “Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам”-ын 2 ба 4 дүгээр бүлэгт заасан шаардлагыг дагаж мөрдөнө.

2.2 Аюултай ачааг усан замаар тээвэрлүүлэхээр санал болгож буй аливаа этгээд нь /цаашид “тээвэрлүүлэгч” гэх/ эрх бүхий этгээдээр баталгаажуулсан тээврийн баримт бичгийг гурван хувь үйлдэж, хоёр хувийг нь тээвэрлэгчид хүлээлгэн өгөх ба тээвэрлэгч нэг хувийг нь өөртөө үлдээж, нөгөө хувийг нь ачаа хүлээн авагчид ачаатай хамт хүлээлгэн өгнө.

2.3 Тээврийн баримт бичигт ачааны оноосон нэр, ачааны ангилал ба бүлэг, Нэгдсэн үндэстний дугаар (өмнө нь UN үсгийг тавина), савлалтын багц, ачааг илгээгч болон хүлээн авагчийн нэр хаяг, аюултай ачааны техникийн зааварчилгаанд заасан бусад шаардлагатай мэдээлэл, тэмдэглэгээнүүдийг хийсэн байна.

2.4 Аюултай ачаанд зориулагдсан хайрцаг, сав, баглаа, боодол болон гадуур баглаа боодол нь тухайн аюултай ачааны техникийн зааварчилгааны дагуу үйлдвэрлэгдэж, бэлтгэгдэж, засварлагдсан байна.

2.5 Аюултай ачаа агуулсан хайрцаг сав, баглаа боодол болон гадуур баглаа боодлын шошго нь тухайн ачааны нэр төрлийг заасан байх ба шошгон дээр аюулын талаарх анхааруулгыг эх хэл дээрээ болон англи хэл дээр бичсэн байна.

2.6 Аюултай ачааны тээвэрлэлтэд оролцох аливаа этгээд нь эрх бүхий байгууллагаас баталсан хөтөлбөрийн дагуу зохион байгуулсан сургалтад хамрагдсан, түүнийг нотолсон баримт бичиг /гэрчилгээ/-тэй байна.

2.7 Мөн тухайн аюултай ачааны техникийн зааварчилгаанд заасан ерөнхий ба нэмэлт шаардлагуудыг хангасан тухай баталгааг бичгээр гаргасан байна.

2.8 Тээвэрлэгч, түүний багийн гишүүд, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцох бүх ажиллагсад аюултай ачаатай холбогдон үүсч болзошгүй онцгой нөхцөл байдлын үед авах арга хэмжээний зааварчилгаа өгч, аюултай ачааны техникийн зааварчилгад тусгагдсан шаардлагатай бусад мэдээллээр хангана.

2.9 Аюултай ачаа тээвэрлэх маршрутыг Улсын мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын ерөнхий газар, Цагдаагийн төв байгууллага, тэдгээрийн эрх олгосон байгууллага, албан тушаалтнаар батлуулсан байна.

2.10 Аюултай ачаа тээвэрлэх буюу ачиж буулгах ажиллагааны үед тухайн аюултай ачааны ангилалаас нь хамааруулан бүх талын аюулгүй байдлыг хангахад шаардлагатай багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, эд зүйлсийг бэлтгэсэн байна.

2.11 Аюултай ачааг ачиж буулгах үйл ажиллагааг зөвхөн өдрийн цагаар хийж гүйцэтгэх ба болзошгүй аюул ослоос сэргийлэх арга хэмжээг урьдчилан авсан байна.

2.12 Аюултай ачаатай холбогдсон зөрчил, осол гарсан тохиолдолд холбогдох байгууллага, албан тушаалтанд нэн даруй мэдээлж, шаардлагатай арга хэмжээг шуурхай авна.

2.13. Усан замын тээврийн хэрэгсэлд ачаалах, түүнээс буулгах болон тээвэрлэлтийн явцад аюултай ачааны хайрцаг, сав, баглаа боодол эвдэрч гэмтсэн болон асгарч гоожсон тохиолдолд ачааг ачсан ачиж буулгах төхөөрөмжийн гэмтэл, усан замын тээврийн хэрэгслийн тавцангийн бохирдлыг шалгаж, нөхцөл байдлыг үнэлэх боломжтой, эрсдэл багатай тохиолдолд зохих сургалтад хамрагдсан, хөдөлмөр хамгааллын хувцас бүхий ажилтан зориулалтын төхөөрөмж, тоноглол хэрэгслээр цэвэрлэж болно. Их хэмжээний аюул учруулж болзошгүй бохирдлыг зохих байгууллагад мэдэгдэж хор уршгийг арилгуулна.

2.14. Цацраг идэвхит болон химийн хорт бодис зэрэг хор, аюулын өндөр зэрэгтэй бодис асгарч гоожсон тохиолдолд аливаа үйл ажиллагааг зогсоож энэ тухай холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдээлэх бөгөөд бохирдлыг цэвэрлэхэд хэрэглэсэн цэвэрлэх бодис, бохир усыг гол, мөрөн, нуурын усанд болон газрын хөрсөнд ил орхилгүй аюулгүй байдлыг хангах шаардлагатай арга хэмжээг зохих байгууллагад мэдэгдэж авахуулна.

2.15 Аюултай ачааны техникийн зааварчилгаанд тухайн аюултай ачааг бусад ачаатай хамт тээвэрлэхийг хориглосон байвал усан замын тээврийн хэрэгсэл дээр өөр өөр хэсэгт тээвэрлэх ба боломжгүй тохиолдолд хамт тээвэрлэхийг хориглоно.

2.16 Зорчигчид болон мал амьтан, ахуйн хэрэгцээний ачаа, хүнсний бүтээгдэхүүнийг аливаа ангиллын аюултай ачаатай хамт тээвэрлэхийг хориглоно.

2.17 Аюултай ачааны техникийн зааварчилгад зааснаас бусад тохиолдолд бүх төрлийн аюултай ачааг багийн гишүүд болон зорчигчдын гар тээш болон биед нь авч явахыг хориглоно.

2.18 Аюултай ачааг тухайн аюултай ачааны техникийн зааварчилгааны дагуу ачааг ачиж тээвэрлэхээр тусгайлан тоноглон бэлтгэсэн буюу зориулалтын усан замын тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.

2.19 Аюултай ачаа тээвэрлэх зориулалтын усан замын тээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт оруулж техникийн бүрэн бүтэн байдлын шаардлага хангасныг баталгаажуулсан байна.

2.20 Тээвэрлүүлэгч аюултай ачаагаа тээвэрлүүлэх хугацаагаа тээвэрлэгчтэй урьдчилан тохирсон байна.

3. Тээвэрлэгчийн бүрэн эрх

3.1 Тээвэрлэгч аюултай ачааг хүлээн авах ба хүлээлгэж өгөх ажиллагааг тээвэрлүүлэгчийн зохих зөвшөөрөл бүхий зогсоол, талбай, агуулахад, тээвэрлүүлэгчийн ачигч нар, ачих буулгах тоног төхөөрөмжөөр гүйцэтгүүлнэ.

3.2 Аюултай ачааг хүлээн авах, хүлээлгэж өгөхөд үүсч болзошгүй аливаа аюул ослоос урьдчилан сэргийлэх үүднээс тээвэрлүүлэгч, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хяналтын дор аюулгүй байдлыг ханган гүйцэтгэнэ.

3.3 Тээвэрлэгч дараах тохиолдолд тухайн аюултай ачааг тээвэрлэлтэд хүлээн авахаас татгалзана. Үүнд:

3.3.1 тухайн аюултай ачааг хүлээн авах, хадгалах болон ачиж тээвэрлэх ажиллагаа нь аюултай ачааны техникийн зааварчилгааны дагуу явагдах боломжгүй буюу түүний техникийн зааварчилгаанд усан замаар тээвэрлэхийг хориглосон байвал;

3.3.2 аюултай ачааны баталгаажсан тээврийн баримт бичиг, тэмдэг тэмдэглэгээ, шошго болон бусад нарийвчилсан тодорхойлолтуудыг тээвэрлүүлэгчээс шаардаж эдгээр нь бүрэн бус байвал;

3.3.3 аюултай ачааг хүлээж авах үед тэмдэглэл, дагалдах баримт бичигт тусгагдсанаас өөр эсхүл заасан жингээс зөрүүтэй тохиолдолд акт үйлдэж хүлээж авахаас татгалзана;

3.3.4 аюултай ачааны сав, баглааны гадаргуу дээр асгарсан, гоожсон шинж тэмдэг илэрсэн тохиолдолд тээвэрлэлтэд хүлээн авахгүй.

3.4 Тээвэрлэлтэд хүлээн авсан, эсхүл тээвэрлүүлэхээр санал болгосон аюултай ачаа нь энэхүү журмын шаардлагуудад нийцэх эсэх нь эргэлзээтэй байгаа тохиолдолд холбогдох байгууллагад мэдэгдэн шинжилгээ хийлгэх, шалгуулж тодруулж болно.

3.5 Усан замын тээврийн хэрэгсэлд аюултай ачааг ачаалахдаа тэдгээрийн сав, баглаа, боодол бүрийг хөдөлгөөн эхлэх, хүчээ авах, эргэх, тойрох, тоормослох, давалгаатай үеийн хазайлт зэрэгт тавцан дээр хөдөлгөөнгүй байлгахын тулд тавцан дээр найдвартай сайн бэхэлж тогтооно. Хэрэв давхарлаж ачих шаардлага гарвал доорх ачаагаа гэмтээхгүйгээр бат бөх, найдвартай сайн зориулалтын жийрэглэх материалаар жийрэглэж ачина.

3.6 Шилэн савлагаатай аюултай ачааг бат бөх хайрцагт үл шатах, шингээх чанартай материалаар жийрэглэж, хөдөлгөөнийг хязгаарлан байрлуулж тээвэрлэнэ.

3.7 Аюултай ачааг хүлээж авсан тээвэрлэгч нь уг ачааг ачиж буулгах, хурааж байрлуулах болон тээвэрлэхдээ аюултай ачааны техникийн зааварчилгад заасны дагуу салгах, тусгаарлах зэргээр аюулгүй ажиллагаанд тавигдах шаардлагыг дагаж мөрдөн ажиллах ба тээвэрлэгч багийн ахлагч нь гишүүддээ аюултай ачааны шинж чанар, хүрээлэн байгаа орчинд учруулж болзошгүй хор хохирлыг мэдүүлэх, тэдгээрийг ачих, буулгах болон тээвэрлэх үед баримтлах шаардлага, аюултай ачаа тээвэрлэх техникийн зааварчилга, нөхцөл, стандартыг урьдчилан танилцуулж зааварчилгаа өгсөн байх ба эмнэлгийн анхны тусламж үзүүлэх зэрэг зохих мэдлэг чадвартай болгосон байна.

3.8 Аюултай ачааны тээвэрлэлтийн үед асгарч гоожсон тохиолдолд өөр хоорондоо урвалд орох зэргээр аюул учруулж болзошгүй эд зүйл болон бодисыг нэг дор ачаалахгүй байна.

3.9 Аюултай ачааг усан замын тээврийн хэрэгсэлд ачаалахаас буюу түүнээс буулгахаас өмнө тухайн ачааг агуулсан хайрцаг, сав, баглаа боодол болон ачих буулгах төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг шалгасан байна.

3.10 Аюултай ачааны тээвэрлэлт эхлэхээс өмнө аюултай ачаатай холбогдсон мэдээлэл, осол зөрчлийн үед авах арга хэмжээний талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд бичгээр мэдээлэл өгсөн байна.

3.11 Аюултай ачаа тээвэрлэхтэй холбогдсон хууль тогтоомж, дүрэм, журам, техникийн нөхцөл, стандартыг мөрдөж ажиллана.

3.12 Аюултай ачааг усан замын тээврийн хэрэгслээр тээвэрлэх явцад эсхүл ачиж, буулгах үед онгоцны тавцан болон ачиж буулгах техник, хэрэгсэлд эвдрэл, гэмтэл үүссэн бол тухайн эвдрэл, гэмтлийн шалгааныг тогтоож, засварлах зайлшгүй шаардлагатай арга хэмжээг нэн даруй авч ажиллана.

4. Аюултай ачааг ачиж буулгах болон шилжүүлэн ачих зогсоолд тавих шаардлага:

4.1 Аюултай ачааг илгээгч ба хүлээн авагчийн эзэмшлийн зориулалтын тоног төхөөрөмж, хэрэгслээр тоноглогдсон, зохих зөвшөөрөлтэй зогсоолд ачиж буулгана.

4.2 Аюултай ачааг ачих, буулгах болон шилжүүлэн ачихад аль болох гар ажиллагаанаас татгалзаж, ачиж буулгах зориулалтын машин механизм ашиглана.

4.3 Аюултай ачааг ачих, буулгах болон шилжүүлэн ачих зогсоол дээр тухайн аюултай ачааны ангилалаас хамааран шаардлагатай багаж хэрэгсэл, эд зүйлсийг бэлтгэн хангасан байна. Аюултай ачааг ачиж буулгах ажиллагааг зөвхөн өдрийн цагаар зохион байгуулах ба болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч, бэлэн байдалд ажиллана.

4.4 Аюултай ачааг ачиж буулгах болон шилжүүлэн ачих зогсоол нь орон сууц, нийтийн барилга, байгууламж, бусад аюултай ачаа хадгалах агуулах, ачиж буулгах, шилжүүлэн ачдаг зогсоолоос 100-200 метр хол зайтай байна.

4.5 Аюултай ачааг ачиж буулгах, шилжүүлэн ачихад зориулан зогсоолыг урьдчилан бэлдэж аюулгүй ажиллагааг хангасан байна.

4.6 Аюултай ачааг нийтийн зогсоол, талбайд шилжүүлэн ачихыг хориглоно.

4.7 Аюултай ачааг хүлээлгэж өгөх, хүлээн авахад тээвэрлүүлэгчийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр дур мэдэн ачааг задлах, нээх, буулгах, сэлгэн ачихыг хатуу хориглоно.

4.8 Аюултай ачааг байгалийн болон бусад давагдашгүй хүчин зүйлсээс хамааран тээвэрлүүлэгч хүлээн авах боломжгүй тохиолдолд зориулалтын зогсоолд байршуулан эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүлээлгэн өгнө.

5. Тусгай зөвшөөрөл болон зөвшөөрөл олгох, хяналт тавих байгууллагын бүрэн эрх

5.1. Аюултай ачаа тээвэрлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай Монгол Улсын хуульд заасан эрх бүхий төрийн захиргааны төв байгууллагууд олгоно.

5.2. Усан замын тээврийн хэрэгслээр аюултай ачааны нэг удаагийн тээвэрлэлт хийх зөвшөөрлийг усан замын тээврийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хүн, хуулийн этгээдэд аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын байгаль орчны асуудал хариуцсан албан тушаалтан, тухайн орон нутгийн мэргэжлийн хяналтын газар, цагдаа, онцгой байдлын газар болон эдгээр байгууллагаас томилогдсон албан тушаалтан олгоно.

5.3. Энэ тохиолдолд тээвэрлүүлэгч тухайн төрөл, ангилалын аюултай ачааг тээвэрлэхтэй холбогдсон гарын авлага, аргачлал, арга зүйн зөвлөгөөгөөр усан замын тээврийн үйлчилгээ эрхлэгчийг хангах бөгөөд буруу тээвэрлэснээс үүдэн гарч болзошгүй

аюул, ослоос урьдчилан сэргийлэх талаар зохих байгууллагаас зохион байгуулсан сургалтад тээвэрлэгч, тээвэрлүүлэгч, түүний итгэмжлэгдсэн этгээдүүд хамрагдсан байна.

5.4. Тээвэрлүүлэгч тусгай зөвшөөрөлгүй буюу зөвшөөрлийн хүчинтэй хугацаа дууссан бол аюултай ачааны тээвэрлэлтийг хийхгүй. Үүнд Усан замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар болон эдгээр байгууллагаас томилогдсон усан замын тээврийн улсын байцаагчид хяналт тавина.

5.5. Аюултай ачаа тээвэрлэхтэй холбогдсон осол, зөрчил гарсан тохиолдолд Усан замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Улсын мэргэжлийн хяналтын газрын усан замын тээврийн хяналтын улсын байцаагчид Онцгой байдлын ерөнхий газар болон бусад хууль хяналтын байгууллагатай яаралтай холбоо тогтоож, болзошгүй аюул, ослыг таслан зогсоох арга хэмжээг хамтран авна.

5.6. Аюултай ачаа тээвэрлэх түүнтэй холбоотой бусад үйл ажиллагаатай холбогдсон маргааныг зөвшөөрөл болон тусгай зөвшөөрөл олгосон холбогдох байгууллагууд хүлээн авч, Иргэний хууль, шүүхийн журмаар хянан шийдвэрлэнэ.

5.7. Энэхүү журмын шаардлагыг зөрчсөн болон аюултай ачаа тээвэрлэхтэй холбогдсон аливаа зөрчил дутагдал гаргасан хүн, хуулийн этгээдэд Усан замын тээврийн тухай хууль болон Зөрчлийн тухай хууль бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.